

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

Дархан-Уул аймгийн Засаг даргын Тамгын газар
2024 оны XI сар

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтийн явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
Засгийн газрын тогтоол							
1.	43	Фестиваль зохион байгуулах тухай 2024-01-25 Дугаар 2024_41	3. Фестивалийг зохион байгуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестиваль нь Улаанбаатар хотын Налайх дүүргийн нутаг дэвсгэрт орших Тайж хайрханы бэлд 2024 оны 08 дугаар сарын 16-аас 18-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Дархан-Уул аймгаас аймгийн Засаг Даргын орлогч, Ажлын хэсгийн дарга Б.Жавхлангаар ахлуулан үндсэн оролцогч - 40, зохион байгуулалтад ажиллах-18 нийт 58 хүний бүрэлдэхүүнтэй оролцлоо. - Залуучууд театрын болон СББӨ-ийг өвлөн уламжлагч нийт 27 уран бүтээлч нь 13 уран бүтээлийг отогт, тайзнаа 5 уран бүтээлийг тус тус толилууллаа. Тус фестивальд оролцоход төсвийн төслийг боловсруулж хүргүүлснээр Аймгийн ЗДТГ-ын газраас 28.0 сая төгрөгийг, ЗГХА- Соёл, урлагийн газраас 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгосон. Үүнд: - Зан үйл, язгуур урлагийн өргөөг Залуучууд театрын найруулагч Н.Баярцэнгэл ахалж ажиллав. Залуучууд театрын 16 уран бүтээлч, бага насны өвлөн уламжлагч 4 хүүхэд, МУСТА, Ерөөлч, магтаалч Ц.Дүйнхэрсүрэн, МУСТА, хулсан хуурч Д.Жавзанжав, Ерөөлч магтаалч Б.Дарханням, Хотон бийч Б.Таамж, Ш.Амгалан, Домборчин М.Давани зэрэг 10 гаруй соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч, Ардын авьяастнууд багтсан бөгөөд тэд 3 өдрийн туршид зан үйл, язгуур хэв шинж, нутгийн болон угсаатны онцлогийг харуулсан урлагийн тоглолтыг толилуулсан. Нийт 27 уран			

				бүтээлч ажиллаж 13 уран бүтээлийг отгийн гадна талбайд нийт 14 удаа, Хүндэтгэлийн тайзнаа 5 уран бүтээлийг 1 удаа тус тус тоглов. 21 аймгийн хамтарсан Гала тоглолтод 1 уран бүтээлийг тоглосон. Тус аймагт соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч 90 хүн бүртгэлтэй байдаг. - Гар урлалын өргөөг аймгийн зураач урчуудын эвлэлийн тэргүүн, монгол зураач Н.Хишигбаатар ахалж ажилласан. Тус бүрэлдэхүүнд СББӨ-ийг өвлөн уламжлагч, эсгий урлаач Т.Жаргалсайхан, Монгол дархан, сийлбэрч Г.Эрдэнэтөгс, уран хатгамалч Б.Цэрэнбалжид нар багтаж гар урлалын бүтээлүүдээрээ оролцсон. Мөн 202 оны Нүүдэлчин соёлын наадмын Шилдэг өвлөн уламжлагч, Үндэсний бичиг соёлыг түгээн дэлгэрүүлэгч Ж.Эрхэмсайхан, Б.Булганчимэг нар эртний түүхт хуйлмал номыг урлан, мянган жилийн буурал түүхтэй монгол бичиг соёлын бүтээлүүд, Найрамдлын Дархан, Үлэмжийн тансаг цуврал бүтээлээр тус тус оролцлоо. - СББӨ-ийн өргөөнд төрлөөр Дархан сумын иргэн, СББӨ-ийг өвлөн уламжлагч О.Туул Байгалийн болон сав шим ертөнцийн тухай мэдлэг, зан үйл, Уламжлалт арга ухаан зэрэг ай савын Байгаль хамгаалах уламжлалт арга мэдлэг, зан үйл, Бариа заслын аргаар анагаах арга ухаан, Ургамлын зүйлээр анагаах арга ухаан, Дом, шившлэгийн аргаар анагаах арга ухаан, Зүү тавих арга ухаан, Төөнүүр хийх арга ухаан, Тан бэлдэх арга ухаан, Гүрэм домын арга ухааныг танилцуулж оролцлоо. - Отгийн гадна талбайд СББӨ-ийг өвлөн уламжлагч А.Нямпүрэв хүү Н.Үйтүмэнтэйгээ хамт 3 монгол банхар, 1 тайга нохойтой оролцсон. Орхон сумын малчин, Морин спортын мастер, СББӨ-ийг өвлөн уламжлагч Б.Түмэннаст Морьт харвааны өвөөр оролцсон. Мөн отгийн гадна талбайд аймгийн Музейгээс "Хорол", "Үйчүүр", "Оюуны цэнгэл", "Шагайн наадгай" зэрэг соёлын өв, уламжлалт тоглоом наадгайн боловсролын хөтөлбөрүүдийг			
--	--	--	--	---	--	--	--

				зохион байгуулж зочид, төлөөлөгч 1100 гаруй иргэдэд сурталчлан таниулсан. Мөн үеэр Музейгээс эрхлэн гаргасан Соёлын бүтээлч үйлдвэрлэл "Хөөрхөн Нада-тайгаа цуг хөлөгт тоглоом тоглоцгооё" хөлөгт тоглоомын багцаа танилцуулав. - Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн асарт Соёлын биет бус өв, соёлын бүтээлч үйлдвэрлэгч “Хийморь” брэндийн богцон цүнх, тусгай хэрэгцээт залуусын “Урам төв”-ийн Монгол наадгай Хөлөгт тоглоом, Дархануулын аав ХХК-ийн Боргил саван, эсгий эдлэл, Дархан ширэн урлал ХХК-ийн арьс ширэн бүтээгдэхүүн, Хөөрөг даалингийн худалдаа MOZU брэндийн модон авдар зэрэг нийт 7 байгууллагын 10 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг худалдаалав. - Уламжлалт хоол, идээ ундааны соёлоор АРТГЭР мэдиа групп, Тогоочдын холбооны Дархан салбар тус тус оролцов. Үр дүн: “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд Дархан-Уул аймаг 3 өдрийн турш ардын язгуур урлагийн отгын тоглолт, үзүүлбэрийг 17 удаа, Их тайзны тоглолт 1 удаа тоглож 4691 хүнд толилуулсан, боловсролын хөтөлбөрийг 18 удаа зохион байгуулж 1781 хүн хамрагдсан байна.			
2.	44	Морин хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_59	6. Энэ тогтоолын хэрэгжилтийг шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг жил тутам Засгийн газрын	Залуучууд театр: Тус театр нь “Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилтийг хангаж нийт 7 арга хэмжээ зохион байгуулж, 1224 үзэгчдэд Морин хуур хөгжмийн бүтээлийг хүргэсэн. Үүнд: 1. Залуучуудын театрын Хөгжим ангийн уран бүтээлч морин хуурч МУСТА Д.Баттулга Ерөнхий боловсролын сургуулийн 7,8,9 ангийн сурагчдад “Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх” тухай зарлигийн хэрэгжилтийг ханган хүүхэд багачуудад театрын үйл			

			хуралдаанд танилцуулж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгасугай. (5.“Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээ”-г хавсралт ёсоор баталсугай.)	ажиллагааг танилцуулж морин хуурын талаарх сургалтыг 4 удаа зохион байгуулж 150 гаруй сурагчид хамрагдлаа 2. Цайхун сургуулийн д. Мягмарсүрэн багштай 6а ангийн 28 сурагч, С. Сарантуяа багштай 6б ангийн 26 сурагч, Г. Хулан багштай 7а ангийн 32 сурагч, нийт 86 сурагч 3 багш хамрагдаж, Залуучууд театрын үйл ажиллагаатай танилцан, морин хуур хөгжмийн үүсэл, гарал, хэрэглээ, сурах арга барилын талаар мэдээлэл авч, морин хуур хөгжмөөр үндэсний болон сонгодог зохиолоос тоглож, хүүхэд багачуудын сонирхсон асуултад хариуллаа. 3. Залуучууд театрын хөгжим ангийн уран бүтээлчид 2024 оны 11-р сарын 10-ны өдөр “Эгшиглэнт аялгуу” явуулын тоглолтоор Дархан Номин , Олон улс , Дархан барааны зах , хүнсний захын худалдаа үйлчилгээний 4-н төвүүдэд очиж уран бүтээлийн дээжсээ өргөн барилаа. Тус арга хэмжээнд нийт 600 гаруй ард иргэд хамрагдлаа. 4. Дархан-Уул аймаг дахь ШШГГ 445-р нээлттэй хорих анги, 435 дугаар хаалттай хорих ангийн хүмүүжигч болон газрын бие бүрэлдэхүүнд нийгмийн хариуцлагын хүрээнд “Сэтгэлийн эгшиг” концертыг өргөн барьж 300 гаруй хүмүүжигч нар хамрагдлаа. 5. Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх тухай МУ-ын ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилтийг хангах, үр хойчдоо өвлүүлэн сургаж, үндэсний урлаг, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор Залуучууд театрын морин хуурч, хөгжимчин МУСТ Д. Баттулгатай хамтран ХНО-оор үйлчлүүлэгч хүүхэд багачуудын дунд Номтой аялал-морин хуур сургалтыг 5 дахь удаагаа зохион явууллаа. Аялалд ШУТИС-ийн Дархан дахь салбарын 10-12-р ангийн 80 гаруй сурагч, 3 багш, 2 номын санч нар хамрагдаж, Морин хуур хөгжмийн үүсэл, гарал, хэрэглээ, сурах арга барилын талаар мэдээлэл авч, морин			
--	--	--	---	---	--	--	--

				хуур хөгжмөөр үндэсний зохиолоос тоглож үзүүлээ. Хүүхдийн номын ордон: 1. Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх тухай МУ-ын ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилтийг хангах, үр хойчдоо өвлүүлэн сургаж, үндэсний урлаг, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх зорилгоор Залуучууд театрын морин хуурч, хөгжимчин МУСТ Д. Баттулгатай хамтран ХНО-оор үйлчлүүлэгч хүүхэд багачуудын дунд Номтой аялал-морин хуур сургалтыг 5 дахь удаагаа зохион явууллаа. Аялалд ШУТИС-ийн Дархан дахь салбарын 10-12-р ангийн 80 гаруй сурагч, 3 багш, 2 номын санч нар хамрагдаж, Морин хуур хөгжмийн үүсэл, гарал, хэрэглээ, сурах арга барилын талаар мэдээлэл авч, морин хуур хөгжмөөр үндэсний зохиолоос тоглож үзүүлээ. Хонгор сумын Соёлын төв: 1. Хонгор сумын тариаланчдад зориулан урлагийн тоглолтыг зохион байгуулж 115 хүнд толилуулсан. 2. Хөгжмийн зэмсгийн мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж цэцэрлэгийн ахлах, бэлтгэл бүлгийн хүүхдүүд, ерөнхий боловсролын дунд ангийн нийт 57 хүүхэд хамрагдсан. Үр дүн: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2024 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 09 дугаартай "Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх тухай" зарлигийн хэрэгжилтийг хангаж соёлын 3 байгууллага нь 2024 оны 11 дүгээр сард 10 арга хэмжээг зохион байгуулж нийт 1481 үзэгчдэд түгээн дэлгэрүүлж ажилласан.			
3.	84	2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр	Х.3.5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээр хангалтгүй	 "Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн			

		46 дугаар тэмдэглэл 2022-09-22 Дугаар 2022_46	үнэлгээ авсан Соёлын яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Биеийн тамир, спортын улсын хороо, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Нийслэл, Архангай, Завхан, Дархан-Уул аймаг хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг сайжруулах тодорхой арга хэмжээ авч, үйл ажиллагааны үр дүнг эрс нэмэгдүүлэх ажил зохион байгуулж, гүйцэтгэлийг эргэн тайлагнах.	дэлгэрүүлэх” тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн хэрэгжилтийг хангуулж 2024 оны 9-р сард 7 арга хэмжээ зохион байгуулж 656 үзэгчдэд хүргэж, 10-р сарын байдлаар 22 арга хэмжээг зохион байгуулж 3789 хүнд хүргэж, 11-р сарын байдлаар 10 арга хэмжээг зохион байгуулж 1481 хүнд хүргэж ажилласан байна.			
--	--	--	---	--	--	--	--